



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/155/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Уластай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.08.19 № 120

талай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Отгон сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Отгон сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар ирсэн 11,348.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер, сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас хандвиаар ирсэн 10,937.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, 6,157.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын болон аж ахуйн материалыг данс бүртгэлд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Отгон сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар эд хариуцагч хүүхдийн тоог хоолны тайланд илүү тайлагнаснаар 162.9 мянган төгрөгийн хоолны материал илүү зарлагдсан, мөн хоолны норм, нормативыг сар бүр хянаж зарцуулаагүйгээс 2-9 дүгээр саруудад хоолны зардлыг 4,006.9 мянган төгрөгөөр хэтрүүлж, 10-12 дугаар сард 3,587.9 мянган төгрөгөөр дутуу олгосон, байгууллагын 592 м.кв газрыг бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Отгон сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5

зорилтын хүрээнд 37 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 94 хувьтай үнэлэгдсэн байна.

Тайлант онд 17 орон тоотой, улсын төсвөөс 554,896.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 25,765.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 2,021.0 төгрөг төвлөрүүлэн өглөг, авлага үүсгээгүй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайла

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,200,087.84	157,455,481.23
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	63,560,510.00	109,715,515.89
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	63,560,510.00	109,715,515.89
3121	Төгрөг	63,560,510.00	109,715,515.89
31211	Төрийн сангийн харилцах	63,560,510.00	109,715,515.89
35	БАРАА МАТЕРИАЛ	46,639,577.84	47,739,965.34
351	Түүхий эд материал	13,753,676.00	19,751,426.00
35110	Тусгай зориулалттай материал	13,753,676.00	19,751,426.00
354	Хангамжийн материал	32,885,901.84	27,988,539.34
35410	Бичиг хэргийн материал	98,350.00	61,100.00
35420	Аж ахуйн материал	6,733,450.00	8,689,900.00
35440	Түлш шатах тослох материал	10,782,750.00	7,880,000.00
35450	Барилгын засварын материал	1,270,500.00	155,000.00
35460	Хүнсний материал	6,399,100.00	3,655,787.50
35470	Бусад хангамжийн материал	7,601,751.84	7,546,751.84
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	106,930,030.31	95,141,497.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	106,930,030.31	95,141,497.50
392	Биет хөрөнгө	99,980,030.31	88,521,497.50
39201	Барилга, байгууламж	38,596,250.04	38,596,250.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,262,916.83)	(14,162,916.87)
39205	Машин, тоног төхөөрөмж	68,584,895.46	88,278,375.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,355,332.53)	(44,189,304.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хөгшил	9,770,027.27	12,365,027.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,741,358.74)	(5,836,631.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,250,002.16	21,250,002.16
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,083,436.52)	(8,001,204.64)
39217	Номын фонд	221,900.00	221,900.00
393	Биет бус хөрөнгө	6,950,000.00	6,620,000.00
39301	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
39302	Хасагдуулга	(1,190,000.00)	(1,520,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,290,000.00	6,290,000.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	217,130,118.15	252,596,978.73
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	217,130,118.15	252,596,978.73
51	Засгийн газрын хувь оролцоо	217,130,118.15	252,596,978.73
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	180,859,324.00	180,859,324.00
51101	Өмч: -Төрийн өмч	180,859,324.00	180,859,324.00
512	Хуримтлагдсан үр дүн	(6,978,455.89)	28,488,404.69
51210	Өмнөх үеийн үр дүн	(6,978,455.89)	(6,978,455.89)
51220	Тайлант үеийн үр дүн	-	35,466,860.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,249,250.04	43,249,250.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	217,130,118.15	252,596,978.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	455,379,380.84	608,479,230.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,697,980.84	27,817,230.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,697,980.84	27,817,230.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,035,000.00	2,021,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,035,000.00	2,021,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	18,107,693.00	19,638,480.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	14,555,287.84	6,157,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,681,400.00	580,662,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	396,566,000.00	554,896,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	396,566,000.00	554,896,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,115,400.00	25,765,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,115,400.00	25,765,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	400,501,426.60	573,012,369.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	400,501,426.60	573,012,369.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,389,726.60	572,761,545.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	250,563,232.00	390,871,817.00
210101	Цалин	171,193,343.00	248,125,389.00
210102	Нэмэгдэл цалин	71,851,789.00	133,893,218.00
210104	Урамшуулал	7,518,100.00	8,853,210.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,483,976.00	50,900,112.11
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,232,076.00	34,232,112.11

210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,615,300.00	3,931,600.00
210203	ҮӨМШ өвчний даатгалын шимтгэл	2,039,400.00	2,795,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	498,200.00	1,978,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,099,000.00	7,962,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,516,950.00	26,418,326.02
210301	Гэрэл цахилгааны зардал	2,229,500.00	1,814,976.02
210302	Түлш, халаалтын зардал	8,936,250.00	21,612,750.00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,351,200.00	2,990,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,304,597.00	3,869,605.00
210401	Бичиг хэргийн материал	564,880.00	287,650.00
210402	Тээвэр, шатахууны зардал	1,533,240.00	1,155,805.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,150,000.00	2,426,150.00
210408	Бараа материал актасны зардал	37,056,477.00	-
2105	Нормативт зардал	39,562,890.00	49,957,572.50
210501	Эм	60,000.00	-
210502	Хоол	39,502,890.00	49,957,572.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,520,500.00	5,114,500.00
210604	Урсгал засвар	1,520,500.00	5,114,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	810,000.00	1,480,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	810,000.00	1,480,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,627,581.60	44,149,612.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,553,300.00	4,711,400.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,430,000.00	5,361,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,644,281.60	34,077,012.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,111,700.00	250,823.98
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,111,700.00	250,823.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,111,700.00	250,823.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	54,877,954.24	35,466,860.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,840,304.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,840,304.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(1,840,304.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	53,037,650.24	35,466,860.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	422,716,400.00	582,683,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,035,000.00	2,021,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,035,000.00	2,021,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,035,000.00	2,021,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,035,000.00	2,021,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,681,400.00	580,662,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	396,566,000.00	554,896,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	396,566,000.00	554,896,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,115,400.00	25,765,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,115,400.00	25,765,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	366,053,448.00	533,877,994.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,053,448.00	533,877,994.11
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364,941,748.00	533,627,170.13
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	250,563,232.00	390,871,817.00
210101	Үндсэн цалин	171,193,343.00	248,125,389.00
210102	Нэмэгдэл	71,851,789.00	133,893,218.00
210104	Үр дүнгийн урамшуулал	7,518,100.00	8,853,210.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	32,483,976.00	50,900,112.11
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,232,076.00	34,232,112.11
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,615,300.00	3,931,600.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,039,400.00	2,795,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	498,200.00	1,978,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,099,000.00	7,962,700.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	21,019,700.00	23,515,576.02
210301	Гэрэл цахилгааны зардал	2,229,500.00	1,814,976.02
210302	Түлш, халаалтын зардал	15,439,000.00	18,710,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,351,200.00	2,990,600.00
2105	Нормативт зардал	43,371,420.00	47,214,260.00
210502	Хоол, хүнс	43,371,420.00	47,214,260.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,984,000.00	1,999,000.00
210604	Урсгал засвар	1,984,000.00	1,999,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	810,000.00	1,480,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	810,000.00	1,480,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,709,420.00	17,646,405.00

ДАНС	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	180,859,324.00	596,250.04	(6,978,455.89)	174,477,118.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,859,324.00	596,250.04	(6,978,455.89)	174,477,118.15
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	53,037,650.24	53,037,650.24
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	180,859,324.00	43,249,250.04	(6,978,455.89)	217,130,118.15
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	180,859,324.00	43,249,250.04	(6,978,455.89)	217,130,118.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,859,324.00	43,249,250.04	(6,978,455.89)	217,130,118.15
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	35,466,860.58	35,466,860.58
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	180,859,324.00	43,249,250.04	28,488,404.69	252,596,978.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	- 615,746,100.00	63,560,510.00 510,762,594.11	(63,560,510.00) 104,983,505.89	- 82.95
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	615,746,100.00	510,762,594.11	104,983,505.89	82.95
210	Бараа, үйлчилгээний зардал	615,746,100.00	510,762,594.11	104,983,505.89	82.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,421,500.00	390,871,817.00	90,549,683.00	81.19
210101	Үндсэн цалин	327,497,700.00	248,125,389.00	79,372,311.00	75.76
210102	Нэмэгдэл	152,514,300.00	133,893,218.00	18,621,082.00	87.79
210104	Урамшуулал	1,409,500.00	8,853,210.00	(7,443,710.00)	628.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,630,800.00	50,900,112.11	5,730,687.89	89.88
210201	Тэтгэврийн даатгал	38,509,900.00	34,232,112.11	4,277,787.89	88.89
210202	Тэтгэмжийн даатгал	4,529,500.00	3,931,600.00	597,900.00	86.80
210203	ҮОМШӨ ний даатгал	2,265,200.00	2,795,700.00	(530,500.00)	123.42
210204	Ажилгүйдлийн даатгал	2,265,200.00	1,978,000.00	287,200.00	87.32
210205	Эрүүл мэндийн даатгал	9,061,000.00	7,962,700.00	1,098,300.00	87.88
2105	Нормативт зардал	49,904,500.00	47,214,260.00	2,690,240.00	94.61
210502	Хоол, хүнс	49,904,500.00	47,214,260.00	2,690,240.00	94.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,826,900.00	1,480,000.00	346,900.00	81.01
210806	Мэдээллийн технологийн зардал	1,826,900.00	1,480,000.00	346,900.00	81.01
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	25,962,400.00	20,296,405.00	5,665,995.00	78.18

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,647,400.00	14,990,205.00	5,657,195.00	72.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,315,000.00	5,306,200.00	8,800.00	99.83
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	615,746,100.00	556,917,600.00	58,828,500.00	90.45
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	554,896,600.00	554,896,600.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	554,896,600.00	554,896,600.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	60,849,500.00	2,021,000.00	58,828,500.00	3.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,021,000.00	2,021,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	58,828,500.00	-	58,828,500.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	63,560,510.00	(63,560,510.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	109,715,515.89	(109,715,515.89)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	145.00	145.00	-	100.00
631	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	145.00	145.00	-	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	145.00	145.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	25,765,400.00	25,514,576.02	250,823.98	99.03
21	Урсгал зардлын дүн	25,765,400.00	25,514,576.02	250,823.98	99.03
210	Бараа, үйлчилгээний зардал	25,765,400.00	25,514,576.02	250,823.98	99.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,765,400.00	23,515,576.02	249,823.98	98.95
210301	Гэрэл цахилгаан	5,197,700.00	1,814,976.02	3,382,723.98	34.92
210302	Түлш, халаалт	17,742,700.00	18,710,000.00	(967,300.00)	105.45
210303	Цэвэр, бохир ус	825,000.00	2,990,600.00	(2,165,600.00)	362.50
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	1,999,000.00	1,000.00	99.95
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,000.00	1,000.00	99.95
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	25,765,400.00	25,765,400.00	-	100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,765,400.00	25,765,400.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	25,765,400.00	25,765,400.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ төлөвлөснөөс 94 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 35,466.8 мянган төгрөгөөр буюу 16,3 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өндөр байгаатай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	63,560.5	109,715.5	46,155.0
Авлага	0	0	0
Бараа материал	46,639.6	47,739.9	1,100.3
Үндсэн хөрөнгө	106,930.0	95,141.5	-11,788.5
Нийт хөрөнгө	217,130.1	252,596.9	35,466.8
Өр төлбөрийн дүн	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	217,130.1	252,596.9	35,466.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	217,130.1	252,596.9	35,466.8

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 46,155.0 мянган төгрөгөөр, бараа материал 1,100.3 мянган төгрөгөөр өссөн бол үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 11,788.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 46,639.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 80,858.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан бол 6,157.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын болон аж ахуйн материалыг хандив тусламжаар хүлээн авч 85,915.6 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр оны эцэст 47,739.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 2,650.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 19,638.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл хандив тусламжаар ирснийг орлогот авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 34,077.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант оны эцэст өглөг, авлага үүсгээгүй нь төсвийг зөв зохистой удирдан зарцуулж чадсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 615,746.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 25,765.4 мянган төгрөгөөр, нийт 641,511.5 мянган төгрөг, зардлыг 641,511.5 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 536,277.3 мянган төгрөг буюу 85.6 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 90,549.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 5,730.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 249.8 мянган төгрөгөөр нормативт зардлыг 2,690.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 346.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,665.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөрг ага хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол	641,511.5	536,277.3	105,234.2	83.6
80233	Хүүхэд хамгааллын зардал	811.3	388.0	423.3	47.82
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	1,885.9	763.4	1,122.5	40.48
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	48,518.5	47,214.3	1,304.2	97.31
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,157.8	2,157.8	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	1,634.5	1,140.0	494.5	69.75
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	12,523.5	0	12,523.5	0
81833	Явуулын багшийн үйлчилгээ	9,801.0	4,856.6	4,944.4	49.55
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	536,392.6	452,224.6	84,168.0	84,31
81844	Төвлөрсөн болон гүнзгийрүүлсэн	21.0	18.0	3.0	85.71
83603		2,000.0	2,000.0	0	100
Дүн		615,746.1	510,762.7	104,983.4	83.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109		25,765.4	25,514.6	250.8	99.0
Нийт дүн		641,511.5	536,277.3	105,234.2	83.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 25,765.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 25,513.6 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,999.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 250.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

4	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
	Уран улиастай ХХК /шууд арга/ тендерээр	Хоол хүнс, аж ахуйн материал	7,762.0	9,125.3
2	Шууд аргаар 14 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулсан	Хоол хүнс, аж ахуйн материал	40,756.5	38,089.0
ДҮН			48,518.5	47,214.3

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно. Тендер зарлаад Уран улиастай ХХК шалгарч гэрээ байгуулан ажилласан бөгөөд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, иргэдтэй оны эцэст тооцоо нийлж, өглөг, авлагагүй гэдгээ баталгаажуулж, баримтжуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 400,501.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 6,007.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 4,505.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 573,012.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар тооцож 8,595.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувь буюу 6,446.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,757.8 мянган төгрөгийн алдаа илэрч 162.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7,594.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Эд хариуцагч нь хоолны зарлагын тайланд 62 хүүхэд илүү бичиж хоолны материал зарлагадсан нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж:

1. Хүүхдийн хоолны нормативыг сар бүр мөрдөж ажиллаагүйгээс 2024 оны 2-9 дүгээр саруудад 4 0069 55 төгрөгөөр дутуу, 10-12 дугаар саруудад 3 587 932 төгрөгөөр илүү зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Хоолны нормативыг мөрдөж ажиллах, сар бүр хяналтыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өглөө.

2. Газрын гэрчилгээнд бичигдсэн газрын хэмжээ, үндсэн хөрөнгийн бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэгдсэн дүнгээс 592 м.кв -аар дутуу байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 "үндсэн хөрөнгөнд гарсан хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник технологийн баримт бичгийг гүйцэт бүрдүүлсэн байх", НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Дутуу бүртгэгдсэн газрыг бүртгэлд авах талаар зөвлөмж өглөө.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Үүнээс		Зөвлөмж			
							Загруулсан	Загруу-лаагүй	Тоо	Дүн		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо		Тоо	Дүн
									Тоо	Дүн		
Эд харуулагч нь хоолны зарлагын тайланд 62 хүүхэд илүү бичиж хоолны материал зарлагасан	1	162.9	1	162.9								
Хүүхдийн хоолны нормативыг сар бүр мөрдөж ажиглаггүйгээс 2024 оны 2-9 дүгээр саруудад 4 0069 55 төгрөгөөр дуутуу, 10-12 дугаар саруудад 3 587 932 төгрөгөөр илүү зарлагасан	1	7,594.9					1	7,594.9				
Гаарын гэрчилгээнд бичигдсэн гаарын хэмжээ, үндсэн хөрөнгийн бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэгдсэн дүнгээс 592 м.кв-аар дуутуу байна.	1	0					1	0				
	3	7,757,8	1	162,9			2	7,594,9				

